



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

64101 Номгон, Баянхонгор сум

Утас, факс 70-44-25-84

E-mail: bayankhongor@audit.gov.mn

Г ГУРВАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ Т
ДАРГА Ц.ЭНХБОЛД-д

2017.03.24

№

07

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Гурванбулаг сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төлөвлөсөн горим сорилыг хэрэгжүүлэх явцад:

1. ОНХСангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн "Жи мобайлын сүлжээнд холбогдох "ажлын 45.8 сая төгрөг, "4-р багийн төвийн гаднах хайсны тохижилт"-ын ажлын 2.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон атлаа ажлыг гүйцэтгүүлэн хүлээж аваагүй.

2. ОНХСангийн хөрөнгөөр гүйцэтгэж хүлээн авсан малжуулах төслийн 29.7 сая, усны харуулын байрны 6.0 сая, Дотуур байрны хүүхдийн зөөлөн эдлэл 4.0 сая төгрөгийн хөрөнгийг тус бүр бүртгэлд тусгаагүй байна.

Энэ нь Монгол улсын Иргэний хуулийн 350.1.1-д "гэрээнд заасан ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4-д заасан Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.2-д "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага"—гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4 дугаар зүйлийн 4.1.5-д заасан "Байгуулсан гэрээ, хэлцэл мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм журмын шаардлага, нөхцлийг хангаагүй, 4.1.1-д заасан "Нягтлан бодох бүртгэлийг Нягтлан бодох

516089

бүртгэлийн тухай хууль, холбогдох стандарт, журам, шаардлагын дагуу зохих ёсоор хөтлөөгүй" гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Гэрээний хугацаанд биелүүлээгүй 48.0 сая төгрөгийн дээрх 2 төсөл арга хэмжээг бүрэн гүйцэтгүүлж хүлээн авч, хөрөнгийн бүртгэлд бүртгээгүй 39.7 сая төгрөгийн хөрөнгийг холбогдох байгууллагуудын бүртгэлд тусгах.

2. Албан шаардлагын биелэлтийг 2017.06.25 дотор Баянхонгор аймгийн аудитын газарт ирүүлэхийг Гурванбулаг сумын Засаг дарга Ц.Энхболд, Санхүүгийн албаны дарга П.Тогтохжаргал нарт хариуцуулав.



ӨГСӨН:

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН
АУДИТОР  Б.АЗБАЯР

АЛБАН ШААРДЛАГЫГ

ЗӨВШӨӨРСӨН:

ГУРВАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Ц.ЭНХБОЛД
САНХҮҮГИЙН АЛБАНЫ ДАРГА
П.ТОГТОХЖАРГАЛ

¹. Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-25-84
E-mail: bayankhongor@audit.gov.mn

ХҮРЭЭМАРАЛ СУМЫН ЗАСАГ
ДАРГА Б.ОТГОНБАЯРТ

2017.03.24 № 09

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Хүрээмарал сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төлөвлөсөн горим сорилыг хэрэгжүүлэх явцад ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжиж буй "Цорж 4-р багт аялал жуулчлалын тоног төхөөрөмж авах" арга хэмжээний 10.0 сая төгрөг, "Нийтийн биеийн тамирын талбайтай болох" арга хэмжээний 9339.6 мянган төгрөгийн гэрээний хугацаа дууссан, санхүүжилтийг бүрэн авсан атлаа гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй байна.

Энэ нь Монгол улсын Иргэний хуулийн 350.1.1-д "гэрээнд заасан ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4 дугаар зүйлийн 4.1.5-д заасан "Байгуулсан гэрээ, хэлцэл мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм журмын шаардлага, нөхцлийг хангаагүй" гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Гэрээний хугацаанд биелүүлээгүй 19939.6 мянган төгрөгийн дээрх 2 төсөл арга хэмжээг бүрэн гүйцэтгүүлж хүлээн авах.


516791

2. Албан шаардлагын биелэлтийг 2017.06.25 дотор Баянхонгор аймгийн аудитын газарт ирүүлэхийг Хүрээмарал сумын Засаг дарга Б.Отгонбаяр, Санхүүгийн албаны дарга С.Нархүү нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН:

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН
АУДИТОР  Б.АЗБАЯР



ЗӨВШӨӨРСӨН:

ХҮРЭЭМАРАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Б.ОТГОНБАЯР
САНХҮҮГИЙН АЛБАНЫ ДАРГА
С.НАРХҮҮ